

**Аудитын код: САГ-2018/22/СТА-ТЕЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер С.Оюунгэрэл  
Утас: 261885 Цахим хаяг: [oyungerels@audit.gov.mn](mailto:oyungerels@audit.gov.mn)

Ахлах аудитор Ш.Ичинхорлоо  
Утас: 261740 Цахим хаяг: [ichinkhorloosh@audit.gov.mn](mailto:ichinkhorloosh@audit.gov.mn)

Аудитор С.Энхтуяа  
Утас: 261740 Цахим хаяг: [enkhtuyas@audit.gov.mn](mailto:enkhtuyas@audit.gov.mn)

Улаанбаатар хот



## Агуулга

1	АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН.....	1
2	АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ .....	6
3	АУДИТЫН ТАЙЛАН .....	8
3.1	Оршил .....	8
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	8
3.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	9
3.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	10
3.5	Дотоод аудит .....	11
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	12
3.7	Шилэн дансны мэдээлэл .....	12
3.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	13
3.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	13
3.9.1	Мөнгөн хөрөнгийн талаар.....	13
3.9.2	Авлагын талаар.....	13
3.9.3	Орлогын талаар .....	14
3.9.4	Төсөвт зардлын талаар .....	14
3.9.5	Нягтлан бодох бүртгэл, тайлагналын талаар.....	15
3.9.6	Төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн талаар.....	15
3.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	16
3.11	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд.....	16
3.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	16
3.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбарк.....	17
3.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	17
3.16	Аудитын үр өгөөжийн талаар .....	17
4	МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	18
4.1	Төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн талаар .....	19
4.2	Авлагын талаар .....	20
4.3	Орлогын талаар .....	21
4.4	Бүртгэл, тайлагналын талаар .....	22
5	АУДИТ ХИЙГДСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	23
5.1	Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан.....	23
5.2	Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	24
5.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	25
5.4	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	26
5.5	Аудит хийгдсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	27
	САНХҮҮГИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ.....	30
	Акт, албан шаардлага.....	



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2018.04.25 № 1025

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД  
Ц.НЯМДОРЖ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул Зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig\_Kherem\Yawan\_Bichig\2018\0425SAG14.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

### Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

### 3 АУДИТЫН ТАЙЛАН

#### 3.1 Оршил

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд Хууль зүй, дотоод хэргийн яамны санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд тайлант онд авлага нэмэгдүүлэхгүй байх, үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрэн тайлагнах, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

#### 3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /цаашид УСНББОУС гэх/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 5-ны өдрөөс 2018 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ш.Ичинхорлоо, аудитор С.Энхтуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт





2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 1-1/1669 тоот албан бичгээр буюу Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

### 3.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хууль зүй, дотоод хэргийн сайд Монгол Улсын Засгийн газрын тухай хуулиар тогтоосон дор дурдсан асуудлуудын бодлого төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх зэрэг чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж байна Үүнд:

- Эрх зүйн шинэтгэлийн бодлого;
- Хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл, эрх зүйн сургалт, сурталчилгаа, судалгаа;
- Хууль эрх зүйн туслалцаа;
- Улсын хил хамгааллын асуудал;
- Цагдаа нийгмийн дэг журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудал;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа;
- Засгийн газраас шүүх, прокурорын байгууллага, хуульчдын олон нийтийн байгууллагуудтай харилцах асуудал;
- Төрөөс сүм хийдтэй харилцах асуудал;
- Иргэний харьяалал, цагаачлалын асуудал;
- Энгийн виз, Монгол Улсад орох, гарах, оршин суух гадаадын иргэний асуудал;
- Төрийн захиргааны байгууллагын шийдвэрийн хууль зүйн үндэслэлийн хяналт;
- Иргэн хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл;
- Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн бүртгэл;
- Оюуны өмч, патент, зохиогчийн эрхийн асуудал;
- Архивын талаар төрөөс баримтлах бодлого зэрэг болно.

Хууль зүй, дотоод хэргийн сайд дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд явуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв.

Хууль зүй, дотоод хэргийн яам 2017 оны үйл ажиллагааны 6 зорилтын хүрээнд 400 ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөж, төлөвлөсөн 300 ажил 100%, 23 ажил 90%-80%, 32 ажил 70%-60%, 40 ажил 60%-50%, 3 ажил 50% доош, 2 ажил огт биелэгдээгүй байна.

- Эрх зүйн бодлого, стратегийн төлөвлөлт;
- Бодлогын удирдамжаар хангах үйл ажиллагаа;
- Төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах ажиллагаа;
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, санхүүгийн зохицуулалтаар хангах үйл ажиллагаа;
- Гэрээ, эрх зүй, хамтын ажиллагаа;
- Эрх зүйн шинэтгэл, бодлогын хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод аудит хийх үйл ажиллагаа;

Төлөвлөсөн үйл ажиллагааны хүрээнд гүйцэтгэсэн зарим гол гол ажлуудыг тодруулбал:

- 2017 онд Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанаар нийт 14 хууль тогтоомжийг боловсруулж батлуулсан,
- Улсын Их Хуралд 3 хуулийн төслийг боловсруулж өргөн барьсан.
- Засгийн газрын тогтоолын төсөлд нийт 397 санал боловсруулан хүргүүлж, 73 хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж хүргүүлсэн,
- Засгийн газрын хуралдаанаар 10 хуулийн төслийг хэлэлцүүлэхээр зөвшөөрөл олгосон.
- Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх 41 хууль, тогтоолын төслийг эцэслэн хянаж зөвшөөрөл олгосон.
- Захиргааны хэм хэмжээний нийт 424 актыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хяналтаар үзэж 135 актыг нэгдсэн бүртгэлд бүртгэж,



- 105 актад дүгнэлт хүргүүлж, 47 актыг хуульд заасан бүрдлийн шаардлага хангаагүй тул буцааж, нэмэлт өөрчлөлт оруулсан 35 акт, хүчингүй болгосон 50 актад холбогдох өөрчлөлт хөдөлгөөнийг хийсэн.
- 2017 онд Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 139 эрх зүйн актыг бүртгэж, нэмэлт өөрчлөлт оруулсан 35, хүчингүй болгохоор ирүүлсэн 30 актыг хүлээн авч холбогдох өөрчлөлт хөдөлгөөнийг хийж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрээс хасалт хийлгэхээр ирүүлсэн 12 албан бичгийн дагуу 48 эрх зүйн актыг улсын нэгдсэн бүртгэлээс хасалт хийсэн.
- Иргэд, байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангаас нийт 114 лавлагаа өгч ажилласан байна.
- “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2017 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 28/А/49/А-141 захирамж/тушаал батлагдаж, холбогдох захиргааны болон хуулийн байгууллагын нийт 180 албан тушаалтныг сургагч багшаар бэлтгэж, хуулийн үзэл баримтлалыг таниулж мэдлэг олгох зорилго бүхий сургалтыг зохион байгуулж, нийслэлд 400 улсын байцаагч, 1200 цагдаа, прокурор, захиргааны байгууллагын ажилтан, улсын өмгөөлөгч нийт 1600 оролцогч, орон нутагт холбогдох төрийн байгууллагын 4991 алба хаагчийг тус сургалтад хамруулсан байна.
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах нэр бүхий 35 журам боловсруулахаас Хууль зүй, дотоод хэргийн сайд дангаар 11, бусад эрх бүхий албан тушаалтантай хамтран 6 журам батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан.
- Харьяа агентлаг, байгууллагуудын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд гадаад орны ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтран ажиллах тухай нийт 12 санамж бичиг, гэрээний төслийг хянан, чиглэл өгч ажиллажээ.

### 3.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 3.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 9 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 19 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим, сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 3.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Хууль зүй, дотоод хэргийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2015 онд боловсруулж баталсан бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт дараах нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Үүнд:

- 2015-2017 онуудад Сангийн яамнаас авч хэрэгжүүлж шинэчлэлт;



- Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх тухай Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам, маягт, аргачлалын талаар;
- Төсвийн орлого, зарлагын эдийн засгийн ангилал, тэдгээрийн бүртгэл, тайлагнал;
- Системийн дотоод шилжүүлэг, хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн бүртгэл тайлагнал;
- Салбар байгууллагуудын үйл ажиллагааны онцлог, тэдгээрийн нягтлан бодох бүртгэл, тайлагналын талаар.

Хууль зүй, дотоод хэргийн яамны санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл дунд буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагатай боловч уг мэргэжилтний орон тоо байхгүй тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хууль зүй, дотоод хэргийн яам нь санхүүгийн тайланг бэлтгэхэд нягтлан бодох бүртгэлийн “асолус”, “э-тайлан” програм хангамжийг ашиглажээ.

### 3.5 Дотоод аудит

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хууль зүй, дотоод хэргийн яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтыг “дунд” гэж үзлээ.

Аудитын явцад төлөвлөсөн горим, сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа

Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэдэх Дотоод аудитын хороог Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны А/72 3 тушаалаар шинэчлэн байгуулсан байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын албан хаагчдыг чадваржуулах сургалтын жилийн хөтөлбөр боловсруулан батлуулж, хөтөлбөрийн дагуу нийт 4 удаагийн сургалтанд хамруулсан байна.

2017 онд Дотоод аудитын хороо нь дотоод аудитыг 5, хяналт шалгалтыг 2, нийт 7 байгууллагад хийж, нийт 139 заалт бүхий зөвлөмжийг өгч, хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

Энэхүү дотоод аудитаар: Хууль зүй, дотоод хэргийн яамны өмч хөрөнгийн бүртгэл, хадгалалт, хамгаалалт, ашиглалт, зарцуулалт, жижиг мөнгөн сангийн зарцуулалт, Үндэсний аудитын газар болон бусад мэргэжлийн байгууллагуудын хийсэн аудит болон шалгалтаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэрэг асуудлуудыг хамруулсан байна.

Дотоод аудитын алба нь байгууллагын санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудлуудад дотоод хяналтыг хэрэгжүүлэн илэрсэн алдаа зөрчил холбогдох зөвлөмжийг өгч ажилласан боловч цаашид Салбарын хэмжээнд мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлого, хэрэгжилт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлан бэлтгэх, нэгтгэх, нэгтгүүлэх үйл ажиллагаанд хэрэгжүүлэх дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай гэж үзлээ.



Хүснэгт №1. Хууль зүй, дотоод хэргийн яамны Дотоод аудитын хорооны 2017 оны дотоод аудитын ажлын зарим үзүүлэлт

№	ҮЗҮҮЛЭЛТ	ДҮН	
1	Хийхээр төлөвлөсөн шалгалтын тоо	21	
2	Гүйцэтгэсэн шалгалтын тоо	21	
3	Шалгалтад хамрагдсан байгууллага, нэгжийн тоо	7	
4	Илрүүлсэн нийт зөрчлийн	Тоо	139
		Дүн (сая.төг)	Тоон дүнгүй
5	Өгсөн зөвлөмжийн	Тоо	139
		Дүн (сая.төг)	-
6	Тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын	Тоо	-
		Дүн (сая.төг)	-

Эх сурвалж: Хууль зүй, дотоод хэргийн яамны Дотоод аудитын хороо

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Хууль зүй, дотоод хэргийн яам 7 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчид батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж нийт зардалд 444,755.3 сая төгрөг, үүнээс урсгал зардалд 432,009.8 сая төгрөг, хөрөнгийн зардалд 33,346.2 сая, эргэж төлөгдөх зээл /Банк хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын алба/ -20,600.7 сая төгрөгийг баталсан байна.

Төсөвт зардлын гүйцэтгэл нийт дүнгээрээ 1.0 хувиар буюу 4,570.9 сая төгрөгийн хэмнэлттэй байна. Урсгал зардалд 427,478.2 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 4,531.6 сая төгрөгөөр, хөрөнгийн зардалд 33,306.2 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 40.0 сая төгрөгөөр тус тус хэмнэжээ.

Төсвийн орлогын төлөвлөгөөг 41,724.1 сая төгрөгөөр баталсан бөгөөд 41,253.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 471.0 сая төгрөгөөр тасарсан байна.


### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг зэргээр системийн хэмжээнд байршуулбал зохих 31,707 мэдээллээс 29,578 мэдээллийг байршуулж, 2,129 мэдээллийг байршуулаагүй ба Шилэн дансны хуулийн хэрэгжилт 93.2 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дараах нийтлэг алдаа зөрчлүүд гарсан байна. Үүнд:

- Шилэн дансны цахим хуудсанд байршуулвал зохих мэдээллийг шалтгаангүй хоцроосон;
- Хэрэглэгчийн эрх, байгууллагын админ эрх, Аудитын эрхийн ашиглалт хангалтгүй;
- Зарим байгууллагууд дээд шатны байгууллагад ирүүлэх улирын тайлангаас бүрэн илгээдэггүй;
- Мэдээлэгдсэн мэдээллийн тоо хоорондоо зөрүүтэй илэрхийлэгдсэн.



- Мэдээллээ хугацаандаа байршуулсан боловч баталгаажуулалт хийгээгүй;
- Бүтцийн өөрчлөлтөөр татан буугдсан газруудын талаар цахим хуудсанд мэдээлээгүй.

Дээрх мэдээллийн нотлох баримтыг ажлын баримт материалд хадгалав.

2017 онд Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар, Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит, өгсөн үнэлгээгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 94.1 хувьтай байна.

### **3.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 9 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 19 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим, сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны "Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах" гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим, сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3.9-д хураангуйлан тэмдэглэв.

### **3.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл**

#### **3.9.1 Мөнгөн хөрөнгийн талаар**

2016 онд татан буугдсан Тахарын албаны ахмадын сангийн үлдэгдэл 49.5 сая төгрөгийг төсвийн нэгдсэн дансанд татан төвлөрүүлэлгүйгээр 2 жил төрийн сан дахь харилцах дансанд байлган үлдэгдлээр бүртгэж, тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", 6 дугаар зүйлийн 6.6.6-д "тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх", 43 дугаар зүйлийн 43.5-д "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр жил дамжуулан зарцуулахгүй" гэснийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

#### **3.9.2 Авлагын талаар**

а) 2017 онд авлага нийт дүнгээрээ буурсан боловч ажиллагсадтай холбоотой авлагыг 29.3 сая, татвар, НДШ-ийн авлагыг 97.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн нь ажиллагсад олгосон урьдчилгаа цалинг тайлант онд суутган тооцоогүй, төсвийн хэмнэлтийг татвар, нийгмийн даатгалын байгууллагад урьдчилан шилжүүлсэнтэй холбоотой байна.

б) 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын анхаарал татахуйц бусад асуудал хэсэгт тусгагдсан 2009 онд хүлээн авсан банк, хадгаламж зээлийн хоршооны эзэн холбогдогч, хариуцагчаас авах зээлийн авлага, өглөгийн материалд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах боломжгүй 16,900.0 сая төгрөгийн талаар тодорхой арга хэмжээ авч холбогдох шийдвэр гаргуулаагүй, мөн уг авлага, өглөгийг хүлээн авснаас хойш буюу 2009-2017 оны хооронд эзэн холбогдогч, хариуцагч нь нас барсан, хөөн хэлэлцэх хугацаа дууссан, шүүхээр хүчингүй болсон зэрэг шалтгаанаар шийдвэр гүйцэтгэх боломжгүй болсон авлага, өглөгийн судалгааг гаргаж, холбогдох ажлын хэсгийн дүгнэлт гаргуулан тухайн байгууллагад шилжүүлэх зэргээр авлага, өглөг бууруулах, барагдуулах талаар өнөөг хүртэл тус тус тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.



Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Шийдвэрлэсэн нь: а) Ажиллагсадтай холбоотой авлагыг тухай бүр суутган тооцох замаар барагдуулж, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг урьдчилан шилжүүлж авлага үүсгэхгүй байх зөвлөмж өгөх,

б) Банк, хадгаламж зээлийн авлага, өглөгийн шийдвэр гүйцэтгэх боломжийн судалгааг гаргаж, найдваргүй болсон авлага, өглөгийг Сангийн яам, Хууль зүй дотоод хэргийн яамны хамтарсан ажлын хэсгийн дүгнэлт гаргуулан, холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэх.

### 3.9.3 Орлогын талаар

а) Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогын батлагдсан төлөвлөгөөг 3.7 хувь буюу 613.3 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлж, Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийг зөрчсөн байна.

б) Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан дахь нэмэлт санхүүжилтийн орлого нь мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлангийн нэмэлт санхүүжилтийн орлогоос 979.7 сая төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэж заасныг мөрдөж ажиллаагүйтэй холбоотой байна.

Шийдвэрлэсэн нь: а) Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг таслахгүй байх

б) Санхүүгийн нэгтгэсэн тайланг НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан холбогдох дүрэм журмын дагуу үнэн зөв бэлтгэх зөвлөмж өгөх.

### 3.9.4 Төсөвт зардлын талаар

а) Хууль зүй, дотоод хэргийн яамны нууцтай танилцах эрх бүхий 38 албан тушаалтанд нууц хамгаалах ажилтны нэмэгдлийг олгож 30.1 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна;

б) Хууль зүйн туслалцааны төв нь ажлын байрны түрээсийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, түрээсийн гэрээний хугацаа сунгаагүй боловч 3.5 сая төгрөгийн түрээсийн төлбөрийг төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д "Нууц хамгаалах ажилтнаас бусаад нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтанд нууц хамгаалах ажилтны цалингийн нэмэгдэл олгохыг хориглоно" гэж заасныг тус тус мөрдөж ажиллаагүйтэй холбоотой байна.

Шийдвэрлэсэн нь: Түрээсийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулалгүйгээр шилжүүлсэн 3.5 сая, нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтнуудад олгосон нууцын нэмэгдэл 30.1 сая төгрөгийн зөрчлүүдийг арилгуулах тухай албан шаардлага хүргүүлэх.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.9.5 Нягтлан бодох бүртгэл, тайлагналын талаар

а) 2017 онд төлбөр хариуцагч иргэн, аж ахуй нэгж байгууллагуудаас авч, Засгийн газрын байгууллага болон хадгаламж зээлийн хоршооны хохирогчдод олгосон 757.7 сая төгрөгийн төлбөрийг тайлант оны зардалд бичсэн нь тайлант оны үр дүнг бодит бусаар өсгөн, 2017 оны тайлант оны үр дүн -959.6 сая төгрөг болсон байна. Мөн 2009-2017 онуудад Засгийн газрын байгууллага болон банк, хадгаламж зээлийн хоршооны хохирогчдод олгосон өглөгийг жил бүр тайлант оны үр дүнд бичиж байснаар байгууллагын хуримтлагдсан үр дүн -8,104.4 сая төгрөгт хүрч, тус байгууллагын цэвэр хөрөнгийн эх үүсвэр хасах үлдэгдэлтэй гарсан;

б) Тайлант онд Банк, хадгаламж зээлийн хоршооны төлбөр барагдуулах ажлын албаны бараа материалын данснаас хасагдсан 2.1 сая төгрөгийн бараа материалын зардал, мөн тайлант онд бэлэн бүтээгдэхүүнийг балансын үнээс доогуур үнээр худалдан борлуулсан боловч бараа материал худалдан борлуулсны гарз /үйл ажиллагааны бус зардал/ 246.8 сая санхүүгийн үр дүнгийн тайланд бүртгэж, тайлагнаагүй байна.

в) Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд нэгдсэн нэг бодлого, арга зүйгээр хангаж, салбар байгууллагуудын төсвийн орлого, зарлагын залруулга хийх, тэдгээрийг баталгаажуулах ажлыг санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэж гаргахаас өмнө хийгээгүй, салбар байгууллагуудын зарим орлого, зардлын эдийн засгийн ангилал зөрүүтэй илэрхийлэгдсэн зэрэг нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийхэд хүндрэлтэй байснаас гадна санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тоон мэдээллүүд нь зөрүүтэй, буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэж заасныг мөрдөж ажиллаагүйтэй холбоотой байна.

Шийдвэрлэсэн нь: 1. Банк, хадгаламж зээлийн авлага, өглөгийг холбогдох стандарт, журам, зааврын дагуу үнэн зөв бүртгэж тайлагнах, Санхүү, төсөв хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон мэргэжлийн байгууллагад хандаж, байгууллагын тайлагнал /хуримтлагдсан элэгдэл болон цэвэр өмч, хөрөнгийн хасах үлдэгдэл/-ийг залруулах албан шаардлага хүргүүлэх,


2. Бараа материалын балансын үнэ болон худалдан борлуулсан үнийн зөрүүгээр олз, гарзыг үнэн зөв тооцон орхигдуулахгүйгээр санхүүгийн үр дүнгийн тайланд тусгаж, тайлант оны үр дүнг үнэн зөв илэрхийлэх, системийн хэмжээнд мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хууль, эрх зүйн актууд, холбогдох журам, зааврын өөрчлөлтүүд болон салбарын үйл ажиллагаа, санхүү бүртгэлийн онцлогт тохирсон бодлого, арга зүйг тусган шинэчилсэн нэмэлт өөрчлөлт оруулан батлуулж, мөрдөж ажиллах зөвлөмж өгөх.

### 3.9.6 Төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн талаар

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 229 нэгж байгууллагын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт гаргахаас Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаалаар 20 байгууллагад "Итгэл" үзүүлж, 56 байгууллага, нэгжид түүвэр хэлбэрээр аудит хийж, 153 байгууллага, нэгжид санхүүгийн тайлангийн аудит хийж санал дүгнэлт гаргасан байна.

Төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагч нарын төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитаар нийт зөрчил илэрсний 24,129.8 сая төгрөгийн 73 алдаа зөрчлийг

САГ-2018/22/СТА-ТЕЗ



сая төгрөгийн алдаа зөрчилд 31 төлбөрийн акт тогтоож, 2,139.7 сая төгрөгийн алдаа зөрчилд 36 албан шаардлага хүргүүлж, 5,167.8 сая төгрөгийн зөрчилд 257 зөвлөмж өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагч нарын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын явцад өгсөн зөвлөмж, албан шаардлага, тогтоосон төлбөрийн акт, залруулгын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг нэгж тус бүрээр гаргаж, ажлын баримт материалд хавсаргав.

